



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар A/171

Арвайхээр сум

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.7.2.1, 1.7.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 9,500,000 (есөн сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга (О.Сумъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0358

Аймгийн Засаг даргын 2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Төсөв
1.	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй-2024” сарын аяныг зохион байгуулах, удирдамж чиглэлийг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргэж, хэрэгжилтийг хангаж ажиллах	04 дүгээр сарын 01-нээс 30-ны өдрүүдэд	3,000,000
2.	“Эрсдэлгүй Өвөрхангай” гар утасны аппликэйшний ашиглалтыг сайжруулах, хөгжүүлэлт хийх	02 дугаар сарын 01-нээс	1,500,000
3.	Сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссын гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Жилдээ	5,000,000
			Нийт: 9,500,000